

ББК
72
А-48



МОНГОЛ УЛСЫН ИХ СҮРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЦЦАНЫ СҮРГУУЛЬ

ББК
72
А-48

АЛТАН АРГАМЖ

Altan Argamj

Journal of foreign affairs & studies
VOL.4(171) 4/2001



Улаанбаатар хот

Монгол Улсын Их Сургууль,
Олон Улсын Харилцааны Сургууль
байгууллаганы 10 жилийн ойд.

АЛТАН АРГАМЖ

2001 №4 (171)

АГУУЛГА

ТЭРГҮҮН ӨГТҮҮЛЭЛ

Л.Эрдэнэчулуун. Глобал ертөнц ба Монгол
улсын гадаад бодлого 5-21

I. ОРЧИН ҮЕИЙН ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Ж.Бор. Монгол яагаад дэлхийн их бодлогын
гадна байдаг вэ? 22-27
Ж.Бор. Монголын "ардчилал" яагаад анархи руу
тулсав? 28-31
Д.Цолмон. Гадаад бодлого, дипломат ажил-
лагааны залгамж, нэгдмэл чанарын тухай
өргүүлэх нь 32-39
Х.Олзёой. Геополитик ба улсын хүч чадал,
бодлого 40-50
Д.Уламбаяр. Монгол улс, Европын Холбооны
харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндэс
тавигдсан нь 51-65
Stephen Noerger. Globalization and Integra-
tion 66-77

Д.Гэрэлтөө. Дараагийн Косово хэзээ бол?
..... 78-82
Timurshilov. G. Decision making in American for
eign policy: Powers of the president 83-85
Khaissandai. L. Support of the Clinton administra-
tion for Mongolia's democracy and renewal ... 86-88

II. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХ

Ч.Далай. Монгол-Хятадын харилцаа ба
Франклин Д.Рузвельт 89-92
Д.Уламбаяр. Монгол-Америкийн харилцаа: XX
зууны эхэн хагаст 93-129
М.Хурметхан. Рузвельт ба АНУ БНМАУ-ын
статус-квог хүлээн зөвшөөрсөн нь 130-135
Ж.Баясах. XIV-XVII зууны Монголын гадаад
харилцаа 136-142
Л.Бэгзжае. Р.Никсон ба Хятад-Америкийн
харилцааны шинэ үе 143-147
Amur Sanathu. India and her relationship with
Mongolia 148-152
Т.Намжил. Их гэр бүл 153-160

III. ГЕОПОЛИТИК, ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ

Х.Олзёой. Монгол улсын талаар явуулж буй
БНХАУ-ын геополитикийн зарим асуудал
..... 161-171
Х.Олзёой. ОХУ-аас Монголын хувьд явуулж
буй геополитикийн зарим үзэл санаа 172-178
Д.Уламбаяр. Олон улсын эрх зүйн уламжлал ба
Чингис хааны "Их засаг" цааз 179-187
Б.Оюунчимэг. Олон улсын иргэний эрх зүй дэх



IV. ДУРСАМЖ

Хван Гил Син. Монголд ажиллах томилолтоо
дуссаад 197-203

V. ОЮУТНЫ БҮТЭЭЛЭЭС

А.Амарсанаа. Олон улсын харилцааны онолын
сургуулиудыг судлах ач холбогдол 204-208
Я.Болд-Эрдэнэ. Дэн Сяопины үеийн БНХАУ-
ын гадаад бодлого 209-213

ТЭРГҮҮН ӨГТҮҮЛЭЛ

ГЛОБАЛ ЕРТӨНЦ БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО

"21 дүгээр зууны эхэн үеийн Монгол Улсын
гадаад орчин, гадаад бодлого" сэдэвт
багахуралд ГХ-ийн сайд Л.Эрдэнэчулууны
(Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд)
тавьсан шлгтгэл

2001 оны 3 дугаар сарын 23 – ны өдөр,
Улаанбаатар хот

Ноёд, хатагтай нар аа,

Та бидний оролцож буй энэхүү бага хурал шинэ он, шинэ зуун,
шинэ мянганы эхэнд болж байгаагаараа онцлог болж байна.
Монгол Улсын гадаад харилцаа энэ шинэ үеийн нөхцөл, хэрэгцээ
шаардлагад яаж зохицох, тулгарч буй асуудлуудыг хэрхэн
шийдвэрлэх вэ гэдэгт уул бага хурлын хэлэлцүүлэг ихээхэн тус
нэмэртэй болно гэж найдаж байгаага энэ ялдамд хэлүүлштэй
байна.

1. Өнгөрсөн хорьдугаар зуун бол Монгол Улсын хувьд үндэсний
сэргэн мандлын эрин үе байлаа. Одоогоос 100 жилийн өмнө, 1901
онд Монгол гэж бие даасан улс байсангүй. Турга тусгаар улс
болоход бидэнд 1911 оны үндэсний сэргэлт, 1921 оны ардын
хувьсгал асар их түлхэц болсон юм. Энэ үеийн Монгол Улсын
гадаад бодлого нь Монголыг тусгаар улс болгох, нэгэнт олсон
тусгаар тогтнолыг бэхжүүлэх, дэлхийн улс орнуудаар хүлээн
зөвшөөрүүлэх, улмаар олон улсын тавцанд түүний байр суурийг
бэхжүүлэхэд чиглэж ирсэн. Үүний ачаар өнөөдөр Монгол Улс орчин
үеийн олон улсын харилцаанд хууль ёсныхоо байр суурийг нэгэнт
эзэлж, олон улсын хамтын нийгэмлэгийн нэр хүндтэй гишүүн
боллоо. Энэ бол Монгол Улсын гадаад харилцааны салбарт ажил-
ласан олон үеийнхний тэмцэл, нөр их хөдөлмөрийн үр дүн байлаа.

Өнгөрсөн зууны сүүлийн арван жилд хүйтэн дайн дуусч, Монголын уламжлалт түнш ЗХУ, социалист хамтын нөхөрлөл нуран унаж Монголын эргэн тойронд цоо шинэ байдал бий болсон юм. Монгол орны дотоодод ардчилалын үйл явц өрнөж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлд шилжих, захираадалтаас ардчилсан тогтолцоонд шилжих тэмцэл эхлэсэн юм.

Ардчилсан өөрчлөлтийн жилүүдэд улс төрийн ардчилал, олон ургалыч үзэл бодит зүйл болов. Парламент ёсонд тулгуурласан ардчилсан төрийн тогтолцоо бүрэлдэн тогтож, боловсронгуй болох үе шатандаа явж байна. Эрх зүйн тогтолцоо бүхэлдээ шинэчлэгдэн нийгмийн олон талт харилцааг зохицуулах болов. Улс орны эдийн засагт хувийн хэвшил байр сууриа эзэлж, өмчийн олон хэлбэр бүрэлдэн тогтлоо. Хүний эрх, эрх чөлөөг бодитой хангах талаар томоохон дэвшил гарлаа.

Үүний зэрэгцээ эдийн засаг, үйлдвэрийн сэргэлт удааширснаас ажиглугийд ядуурал өсч байна. Шинээр бүрэлдэн тогтсон төрийн механизм төгөлдөржөөгүйгээс бодлогын алдаа гарах, хэрэгжилт нь хангагдахгүй, хууль зөрчилдөх зэрэг ноцтой үзэгдэл гарч ирж улмаар ардчилал, зах зээлийн боломжийг бүтээлчээр нээн ашиглах боломжийг бууруулж байна.

Жил бүр ДНБ-ний 30 орчим хувьтай тэнцэж байсан ЗХУ –ын тусламж үгүй болж, ЭЗХТЗ-ийн орнуудын зах зээлээс тасарсан нь Монголын эдийн засгийг богино хугацаанд сүйрлийн ирмэгт хүргэж, 1993 оны байдлаар инфляцийн хэмжээ 325 хувьд хүрч байв. Гэвч гадаадын зээл тусламж нэмэгдэж, худалдаа либералчлагдсан зэрэг нь нэгэнт зогссон тусламжийн орон зайг зохих хэмжээгээр нөхөх болсон юм. Үйлдвэрийн газруудын хувьчлалтай холбоотойгоор ажиглугийд өсч, түүнээс үүдэн ядуурал бодитойгоор нүүрлэх болжээ. 1999 оны байдлаар Монголын хүн амын 30 гаруй хувь нь амьжиргааны баталгаат түвшингээс доогуур амь зууж байна.

Бүс нутгийн хөгжлийн түвшний ялгаа ихэссэний улмаас зах хязгаар нутгаас нийслэл болон төв хэсэг рүү шилжин суурьшигчдын тоо ихэсч, алс хязгаар нутгуудад хүн ам цөөрч зэгийрэх, хөгжлөөс улам гээгдэх аюул нүүрлэж байна. Монголын олон мянган иргэн гадаад улс орнуудад цагаачлан ажиллаж, амьдрах боллоо.

Шилжилтийн энэ үеийн Монгол Улсын гадаад бодлогыг 1994

онд баталсан Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлогын үзэл баримтлал тунхаглан зарласан юм. Харьцангуй бие даасан, тэнцвэртэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж, аюулгүй байдлаа хангахдаа зөвхөн нэг улсад биш аль болох олон улс, олон улсын байгууллага, түүнчлэн олон улсын эрх зүйд тулгуурласан үйл ажиллагаа явуулах явдал энэ бодлогын гол цөм нь болсон юм.

Ийнхүү Монголын ард түмэн үндэсний бахархлаа сэргээж, олон улсын харилцаанд нэгэнт баттай байр суурь эзлэн XXI зуунтай золгож байна.

2. Аюулгүй байдлын орчин.

Монгол улсын гадаад аюулгүй байдлын орчинд сүүлийн арван жилд харьцангуй таатай нөхцөл бүрэлдсэнээр үндэсний ашиг сонирхолд нийцсэн, харьцангуй бие даасан гадаад бодлого, хэрэгжүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, аюулгүй байдлыг бэхжүүлэх өргөн бололцоо нээгдлээ.

Олон улсын харилцаанд өдгөө гарч буй дараах чиг хандлага Монгол улсын аюулгүй байдлын гадаад орчинд урт хугацаанд зонхилох нөлөө үзүүлж, улмаар улс орны гадаад бодлогыг тодорхойлох хүчин зүйл боллоо.

2.1. Глобалчлалын үйл явцад Монголын эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал улс орны аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Олон улсын тавцанд, ялангуяа Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж буй улс төр, нийгэм, санхүү-эдийн засаг, цэрэг зэвсэг, байгаль орчны салбар дахь өөрчлөлт хувиралт Монголын байдалд шууд болон дам нөлөөлж эхэллээ.

Глобалчлал, ардчилал түгээмэл шинж чанартай болж, технологийн дэвшил асар хурдацтай өрнөх XXI зуун Монгол оронд түүхэн боломжийг олгож байна. Далайд гарцгүй, газар зүйн хувьд түгжидмэл байршлын сөрөг нөлөөг даван туулж, ард олныхоо оюуны чадамжинд тулгуурлан хурдацтай хөгжих боломжийг мэдээллийн эриний шинэ технологи олгож байна.

Глобалчлалын үйл явц нөгөөтэйгүүр баян хоосны ялгааг улам ихэсгэхэд хүргэж болзошгүй. Энэ байдал ялангуяа Монгол шиг буурай, жижиг улсуудын хувьд эмзэг тусч байгаа. Ийм улсууд хүн төрөлхтөний хөгжлийн голыдролын гадна үлдэх осол нүүрлээд байгааг Манганы чуулганд эдгээр орны төр засгийн тэргүүн нарын хэлсэн үгнээс тодорхой харагдлаа. Глобалчлалын үйл явцыг дагаж зэр зэвсэг, хар тамхины хууль бус наймаа газар авах, хүнийг худалдаалах, интернетийн сүлжээгээр санхүүгийн хууль бус үйлдэл хийх, элдэв вирус тархаах, улмаар улс орнуудын тусгаар тогтнолд аюул занал учруулах нөхцөл байдал ч гарч ирж байна.

Хүн төрөлхтөний өмнө тулгарч буй нийтлэг глобал шинжтэй асуудлуудын тухай бид ярихдаа шинэ зууны эхээр байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гарч буй гамшгийн асуудлыг хөндөхгүй өнгөрч болохгүй юм.

НҮБ-ын цаг уурын асуудлаарх засгийн газар хоорондын Комиссоос өнгөрсөн хоёрдугаар сард гаргасан илтгэлээс үзвэл бидний хойч үеийнхний хувьд хар дарсан аймшигтай зүүдний дүр зураг төсөөлөгдөж байна. Дэлхийн нэртэй 700 эрдэмтэн мэргэд оролцсон эл илтгэлд дурдахдаа, хэрэв дэлхийн цаг уурын дугаарал өнөөгийн хэмжээнд байх ахул хойд туйлын мөс хайлж, дэлхийн ургамал, амьтны ертөнц устан алга болж, Номхон далай, Карибын тэнгисийн арлын улсууд усанд живж орвонгоороо алга болох аюул нүүрлэж байна гэжээ. Эдгээр глобал шинжтэй үзэгдэл дан ганц ядуу буурай орнуудыг нөмрөөд зогсохгүй баян хөгжилтэй улсуудыг ч мөн адилхан нэрвэх ажээ. Илтгэлд хийсэн дүгнэлтээс үзэхэд цаг уурын хувиралтаас үүдэн энэ зуунд хар салхи, үер, ган зудын аюул бараг хэвийн үзэгдэл болох шинжтэй. Ийм бүс нутгаас хүн ам их хэмжээгээр шилжин суурьшиж, олон сая хүн амь насаа алдаж, өвчин дамжуулагч ялаа шумуул олширсноос шалтгаалан шар чийрэг /маларий/ зэрэг өвчин дэлхий даяар тархаж, амьдрах орчин нь /хабитат/ устаж алга болсноос хамаарч дэлхийн улаан номонд орсон ан амьтад бүрмөсөн устах аж. Илтгэлд дурдсанаас үзэхэд байгалийн ийм гамшигтай тэмцэхэд 1950 онд 4 тэрбум ам. доллар гарздаж байсан бол 1999 онд 40 тэрбум ам. доллар зарцуулсан байна.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, Монгол орны экологийн нөхцөл байдал өнгөрсөн зуунтай харьцуулахад ихээхэн муудаж,

үндэсний аюулгүй байдлын томоохон асуудал болоод байна. Энэ нь байгалийн болоод хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нь илт. Монгол оронд сүүлийн хоёр жил болсон зуд турхан ч мөн дэлхийн цаг агаарын дугааралтай холбоотой байлаа. Сүүлийн 40 жилд Монгол орны элсжсэн талбай 6.7 хувиар нэмэгджээ хэмээн Монгол Улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт дүгнэсэн байна. Эрдэмтдийн үзэж байгаагаар манай улсын нутаг дэвсгэрийн 95 хувь нь цөлжилтэд өртөх аюултай гэдэг. Хамгийн сэтгэл сэрэхийлгэмээр зүйл бол байгалийн гамшиг, зудын давтамж улам бүр ойртож байгаад оршино. Үүний зэрэгцээ шүлхий зэрэг малын гоц халдварт өвчний тархалт ч нарны идэвхжилтэй холбоотой гэж эрдэмтэд нотолж буй.

Цаашилбал, дэлхийн хөгжлийн өөр нэг хандлага бол 990-ээд оноос эхэлсэн глобал чанартай ардчиллын үйл явц урт хугацаанд хүний нийгмийн хөгжлийн үндсэн чиг хандлага хэвээр байх төлөвтэй.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи асар түргэн хөгжихийн хэрээр Монголын гадаад харилцаа мөн өргөжин тэлж түүнд хувь хүмүүс, төрийн бус байгууллагууд зэргийн үүрэг, оролцоо өсч байгаа нь бас нэг онцлог мөн.

Түүний сацуу хүний аюулгүй байдлын үзэл баримтлал эдийн засаг, нийгмийн аюулгүй байдлын холбогдол бүхий өргөн утга агуулах болов.

Глобалчлалын үйл явц эрчимтэй өрнөж буй өнөө үед олон улсын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол улам өсч байна.

Хөгжиж байгаа орнууд глобалчлалын үр шимийг эрх тэгш эдлэх асуудлыг шийдвэрлэх гол төв бол НҮБ байх ёстой гэж үзэж буй. НҮБ бол бүх дэлхийн шинжтэй, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, засгийн газар хоорондын цорын ганц механизм гэдэг утгаараа улс хоорондын харилцааны хэм хэмжээ, зарчмыг тогтоох үүргийнхээ дагуу глобалчлалын асуудалд хандах ёстой бөгөөд ийм хэм хэмжээ, зарчим тогтоох үйл явцыг НҮБ-ыг өөрчлөхөөс эхлэх ёстой гэж хөгжиж байгаа орнууд үздэг.

Ийм зарчим, хэм хэмжээнүүдийн тоонд олон талт үйл ажиллагааг эрхэмлэн дээдлэх, ардчилал, яриа хэлэлцээг эрхэмлэх

явдал багтана. Үүнийг ажил хэрэг болгосноор НҮБ дэлхийн улс түмнээс түүнд хүлээлгэсэн үүрэгээ сая биелүүлж чадах юм.

Глобалчлалын асуудлаар ЭУНХ, 77-гийн бүлгийн хүрээнд хөгжлийн түвшингээр адил төстэй улс орнуудтай хамтран ажиллах нь манай гадаад бодлогын чухал чиглэл гэж үзэж байна.

2.2. Хүчний тэнцвэр.

Хүйтэн дайны дараа манай ертөнц хоёр туйлаас олон туйл руу шилжих шилжилтийн үедээ байна. Шилжилтийн энэ үеийн онцлог бол хүчний тэнцвэр тодорхойгүй байгаад оршино. Гэхдээ дэлхийн улс орнууд дотоодынхоо нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудалд түлхүү анхаарч байгаа бөгөөд энэ нь олон улсын харилцааны хөгжлийн цаашдын чиг хандлагыг өөдрөгөөр төсөөлөх үндэс болж байна.

ОХУ-д Ерөнхийлөгчийн засаглал бэхжиж, дотоод байдал нь тогтворжин, БНХАУ-ын эдийн засаг жил дараалан тогтвортой өсч, Японы эдийн засгийн хүчин чадал нэмэгдэхийн хэрээр улс төрийнх нь нөлөө тэлж, Энэтхэг улс эрчимтэй хөгжлийн замд оров.

АНУ-ын шинэ засаг захиргаа глобал болон бүс нутгийн асуудлуудаар баримтлах бодлогоо боловсруулж байна. Европын Холбоо олон улсын харилцааны бие даасан субъект болж, улмаар Дорнод, Төв Европын орнуудыг хамрах замаар өргөжин тэлэх үйл явц бодитой болж байна. Дэлхийн баруун хэсэгт Хойд, Өмнөд Америкийг хамарсан чөлөөт худалдааны асар том төв бий болох эхлэл тавигдаж байна.

Түүхээс өвлөгдсөн ужиг асуудал олонтой, газар нутгийн маргаан намжаагүй, хуваагдмал үндэстнүүдтэй, бие биендээ үл итгэх явдал байсаар байгаа АНД, ЗХА-ийн бүсэд АНУ, Япон, Орос, Хятад, зэрэг дэлхийн том гүрнүүдийн эрх ашиг харилцан солбилцож байдгийг бид мэдэх билээ.

Гэвч өнгөрөгч зууны сүүлчээр эдгээр гүрний хооронд яриа хэлцээ өрнөж, АПЕК, АСЕМ, ПЕКК, ССКАП, АСЕАН-ы Бүсийн чуулга зэрэг засгийн газрын болон засгийн газрын бүс, улс төрийн болоод эдийн засгийн олон талт байгууллагууд үүсэн бий болж үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Монгол Улс АНД-н бүс нутагт бий

болсон албан ёсны болон албан бус яриа хэлэлцээний олон талт эдгээр бүтцийг дэмжиж, энэ нь бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг цаашид өрнүүлэхэд ихээхэн ач холбогдолтой гэж үздэг.

Монгол Улс 1998 оноос АРФ-д оролцох болж, эл үйл явцын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нь ЗХА, нийт Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд Монгол Улсын тухай төсөөллийг өөрчлөх, улмаар итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл болсон юм. БНАСАУ-г Чуулгад 2000 онд элсэн орсноор ЗХА-ийн бүх улс энэ үйл явцын гишүүн болж байгаа бөгөөд АСЕАН-ы Бүсийн Чуулга уулзалт нийт Азийг хамрах боллоо. Өнгөрсөн зууны төгсгөлд бараг хагас зуун жил үргэлжилсэн Солонгосын хойгийн түгшүүртэй байдлыг намжаахад чиглэсэн нааштай алхам гарч эхэллээ. Хоёр Солонгосын харилцаа хэвийн болох нь Солонгосын хойг төдийгүй нийт Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, түүнд Монгол Улсын оролцох томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, түүнд Монгол Улсын оролцох нөхцлийг бүрэлдүүлэхэд чухал гэж бид үздэг.

Солонгосын хойгийн үйл явц нарийн төвөгтэй, олон асуудал агуулж буй хэдийч энэ бүс нутагт эвлэрэх хамтран ажиллах талаар нааштай төлөв харагдаж байна.

Монгол Улсын хамгийн ойрын гадаад орчин ОХУ, БНХАУ-ын харилцаа 1980-аад оны дунд үеэс хэвийн болж, итгэлцэл нэмэгдэж байгаа нь Монгол Улсын хөгжил, аюулгүй байдалд таатай нөхцөл бүрдүүлж байна. Тус хоёр орны удирдагчдын мэдэгдэж байгаагаас үзэхэд Орос, Хятадын харилцаа, хамтын ажиллагаа лав ойрын ирээдүйд тогтвортой хөгжих төлөв харагдаж байна.

Манай хоёр хөршийн болон Зүүн Хойд Азийн гол гол орнуудын хоорондын харилцааны шинж төлөв, хоёр Солонгосын нэгдэх үйл явц, зэс, ноолуур, алт, газрын тосны дэлхийн зах зээл дээрх ханш зэрэг нь 2001 онд болон цаашдаа ч Монголын гадаад орчинд нөлөөлөх хүчин зүйл хэвээр байх болно. Түүнчлэн Төв Азид зэвсгийн хууль бүс наймаа газар авч, шашны харгис урсгал хүрээгээ тэлж, хар тамхины наймаа, олон улсын алан хядах үйл ажиллагаа тасрахгүй байгааг анхаарахгүй байж болохгүй юм.

3. Олон улсын хамтын нийгэмлэгтэй 21 дүгээр зууны эхэнд хамтран ажиллах Монгол Улсын гадаад бодлогын зорилт

Монгол Улсын шинэ Засгийн газраас ойрын жилүүдэд баримтлах гадаад бодлогын зорилт Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан. Энэ илтэлийн эхний хэсэгт миний бие өнөөгийн Монгол орны гадаад орчны талаар төсөөлөл гаргахийг оролдлоо. Одоо энэ орчиндоо хэрхэн яаж зохицох тухай болон мөн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт гадаад бодлогын салбарт дэвшүүлсэн зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх асуудалд Та бүхний анхаарлыг хандуулья гэж бодож байна. Үүнд томоохон хоёр зорилтыг дэвшүүлсэн юм. Монгол Улсын гадаад бодлогын 21 дүгээр зууны эхэн үеийн үндсэн зорилт бол нэгдүгээрт, Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинг шинэ нөхцөл байдалд бэхжүүлэх, хоёрдугаарт, Монгол Улсын үндэсний хөгжилд дөхөм үзүүлэхэд гадаад бодлогыг чиглүүлэх явдал мөн. Энэ бол бидний урт хугацааны зорилт. Энэ зорилтыг шийдвэрлэх арга нь хоёр болон олон талын дипломат үйл ажиллагаа мөн.

3.1. Хөрш орнууд

Олон тулгуурт гадаад бодлого нь хоёр хөрштэй бүхэлдээ тэнцвэртэй, сайн хөршийн харилцаа хөгжүүлэхийн зэрэгцээ манай "гурав дахь хөрш" болох өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнууд түүний дотор, АНУ, Япон зэрэг тэргүүний хөгжилтэй орнууд, НҮБ, ЭУНХ зэрэг олон улсын байгууллага, хөдөлгөөнтэй харилцаагаа улам гүнзгийрүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Хоёр хөрштэй тогтоосон харилцаанд бид тэнцвэртэй байх, сайн хөршийн харилцаа хөгжүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах урт хугацааны зарчмыг удирдлага болгож байгаа юм. Монгол Улс Орос, Хятадын аль алинтай нь найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээтэй. Манай хооронд газар нутгийн болон хилийн ямар нэг маргаан байхгүй бөгөөд энэ нь сайн хөршийн харилцаа хөгжүүлэхэд таатай хөрс суурь болж байгаа юм.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин өнгөрсөн 11 дүгээр сард манай

улсад албан ёсны айлчлал хийлээ. Нэг хэсэг хугацаанд зогсонги байдалд орсон хоёр орны харилцаа сэргэж, цаашид тогтвортой хөгжих үндэс суурь тавигдав. Уг айлчлал хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах тухай Монгол Улсын гадаад бодлогын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн гадаад бодлогын томоохон алхам байлаа.

Хөрш орнууд, Төв Азийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцдэг "Шанхайн тав" хэмээх чуулга уулзалтыг бид анхааралтай ажиглаж үйл ажиллагаанд нь ямар нэг хэлбэрээр оролцох асуудлыг судалж байна.

Ази тивд итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн Казахстаны саналыг Монгол улс дэмжиж байна.

Өдгөө ЗХА-ийн хэмжээнд яригдаж буй Монголын нутгаар дамжуулан байгалийн хий, газрын тос дамжуулах хоолой, өндөр хүчдэлийн шугам, Азийг Европтой холбосон төмөр зам барих зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нь манай хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, бүс нутгийн интеграцчлалын үйл явцыг урагшуулахад ихээхэн ач холбогдолтой. Эдгээр төслийн тухайд манай холбогдох яамд, агентлагууд өөр хоорондоо уялдаатай, судалгаатай үйл ажиллагаа явуулах шаардлага гарч байна.

Японы эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Азийг Европ тивтэй төмөр замаар холбох 9 маршрут байгаа бөгөөд дор хаяад хоёр нь Монголын нутгаар дайран гарах боломжтой байна. Нэг хувилбар нь Алтанбулаг-Замын -Ууд-Тянжин. Энэ шугам одоо ажиллаж байгаа. Хоёрдахь хувилбар нь Чита-Чойбалсан-Аршаант-Түмэн голын чиглэл бөгөөд Чойбалсан-Аршаантын чиглэлд төмөр зам шинээр тавьсан нөхцөлд Хойд, Өмнөд Солонгос, цаашаа Пусан боомтод төмөр замаар хүрэх боломжтой болно.

Төмөр замын энэ шинэ чиглэлийг нээснээр "Манганы Зам"-ын олон улсын ачаа тээврийн ач холбогдол улам нэмэгдэх юм. Өдгөө ЮНКТАД-ын ивээл дор гураван улсын экспертүүдийн хэмжээнд явагдаж буй транзит тээврийн асуудлаархи хэлэлцээг амжилттай дуусгахад ихээхэн хүч чармайлт тавих ёстой.

3.2. Олон талт хамтын ажиглалтаа

Эдүгээ дэлхийн улс орнуудын харилцан хамаарал гүнзгийрч, олон улсын эдийн засаг, аюулгүй байдлын шинэ орчин үүсч байна. Бид НҮБ-ын хүрээнд илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ДХБ, АСЕАН-ы Бүсийн чуулга зэрэг олон улсын байгууллага, чуулга уулзалтад шинээр элссэн.

НҮБ бол Монгол Улсын аюулгүй байдлын чухал баталгаа мөн. Энэ байгууллагын ирээдүйн талаархи байр сууриа бид НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өнгөрсөн чуулганы явцад түгээсэн Санамж бичигт тодорхой тусгасан. Үүнтэй уялдуулан өгүүлэхэд Монгол Улс НҮБ-тай цаашид хэрхэн хамтран ажиллах бодлогоо нарийн нягт тодорхойлох шаардлагатай болж байна. Монгол Улс НҮБ-д элсэн орсны 40 жилийн ойг энэ жил тэмдэглэн өнгөрүүлэхдээ НҮБ болон түүний системийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хэрхэн өрөмжүүлж, үр өгөөжийг хэрхэн дээшлүүлэх вэ? гэсэн асуултыг бид өөрсөддөө тавьж, зорилгоо тодорхойлох учиртай. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний 2009-2010 оны суудалд бид нэрээ дэвшүүлсэн бөгөөд энэ сонгуульд амжилттай оролцохын тулд одооноос төлөвлөгөө тооцоотой ажиглаж, хүч нөөцөө зөв хувиарлаж дайчлан ажиллах шаардлагатай.

Зэвсэг хураах чиглэлд бидний гаргаж байгаа хүчин чармайлтын хувьд 1992 онд Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53, 55 дугаар чуулганаар "Монгол улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус"-ын тухай тогтоолыг баталсан нь манай улсын аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ болсон юм. "Цөмийн зэвсгээс ангид байх тухай" Монгол Улсын хуулийг УИХ-аар баталж Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн хамтарсан мэдэгдэл гаргасан.

Олон улсын энх тайвныг сахин хамгаалахад онцгой үүрэг бүхий таван гүрний мэдэгдэл нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, байгаль орчны зэрэг манай Аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан бүхий л чиглэлээр гадаад аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад чиглэсэн чухал алхам болсон юм.

Ази, Номхон далай дахь Монгол Улсын бодлого нь аюулгүй байдлын олон тулгуурт тогтолцоог бүрэлдүүлэхэд оршино. Энэ бүс нутаг дахь бидний бодлого нэгд, хөрш орнуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцаатай байх, хоёрт, бүс нутгийн бусад улс, оронтой хоёр талын харилцаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлэх, гуравт, АРФ – ын хүрээнд олон талын шугамаар идэвхтэй ажиллах, тухайлбал, ЗХА-д аюулгүй байдлын асуудлуудыг хэлэлцэх механизм бүрэлдүүлэх талаар 1-суваг буюу засгийн газрын хэмжээнд яриа хэлэлцээ эхлүүлэх, дөрөвт, "хоёрдагч" сувгийн үйл ажиллагааг дэмжихэд оршиж байна.

АСЕАН-ы Бүсийн чуулгын хүрээнд бидний явуулах бодлого бол АРФ-ын 1995 оны Үзэл баримтлалд /Concept Paper/ тодорхойлсон гурван үе шатын дагуу тухайлбал, гишүүн орнуудын хооронд итгэлцлийг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагаа явуулах, мөргөлдөөнийг зохицуулах чиглэлээр идэвхтэй ажиглахад оршино. Үүний сацуу бид АПЕК, АСЕМ-д нэгдэх хүсэлтэйгээ илэрхийлсэн.

"Хоёрдагч сувгийн" тухайд гэвэл 1990-ээд оноос Монголын эрдэмтэд судлаачид бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар энэ үйл ажиллагаанд оролцож ирсэн. Манай эрдэмтэд, судлаачид Ази, Номхон далайн аюулгүй байдал, хамтын ажиллагааны зөвлөл, Умард Номхон далайн ажлын хэсгүүдэд идэвхтэй оролцож ажиллаж байгаа. Бүс нутгийн аюулгүй байдлын болон жижиг улсын аюулгүй байдал, хүний аюулгүй байдлын асуудлаар дангаараа болон олон улсын байгууллагуудтай хамтран бид хэд хэдэн удаа олон улсын бага хурал, дугуй ширээний уулзалтыг зохион байгуулах зэргээр ажиллаж байна.

Ноёд, хатагтай нар аа,

Одоо глобалчлалын эринд Монгол орны цаашдын хөгжлийг хангах нийтлэг зорилгод тохирсон гадаад бодлогын зорилтын талаар та бүхэнтэй санаа бодлоо хуваалцъя.

1. Нээлттэй бодлогыг тууштай явуулах нь Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжлийн үрээр мэдээллийн хүртээмж асар их нэмэгдэж, олон улс оронд ардчилсан

засаглал бэхжих үйл явц эрчтэй өрнөж, иргэний нийгмийн үйл ажиллагаа идэвхжиж байна. Үүний сацуу хил дамнасан нийгэм, эдийн засаг, байгаль орчныг хамарсан олон төрлийн асуудлыг хүн төрөлхтөн хамтран шийдвэрлэх шаардлагатай тулгарсан.

Ийм нөхцөлд гадаад харилцаанд оролцогч хэн боловч харилцан ашигтай, нээлттэй хамтын ажиллагааны үзэл санааг эрхэмлэж байх нь нэн чухал юм. "Гадаад бодлогын үзэл баримтлал" нь дээрх үзэл санаанд тулгуурлаж "Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь ... хүн төрөлхтөний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх" явдал мөн гэж тодорхойлжээ.

Эдүгээ цагт Монгол Улс глобалчлалын үйл явцад нэгдэх эсэх талаар сонголт хийх яриа байж таарахгүй, харин улам бүр харилцан хамааралтай дэлхий ертөнцөд өрсөлдөх чадвараа дээшлүүлж, глобал харилцаанд орох тухай асуудал тавигдаж байгаа юм.

Монгол орны нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах шаардлагын дагуу хаалттай бүс нээлттэй байж, глобалчлалын үйл явцтай хөл нийлүүлэн алхах нь манай төрийн бодлого, ялангуяа гадаад бодлогын нэгэн чухал зорилт болж байна.

Монгол Улсын аюулгүй байдал, хөгжил цэцэглэлийг хангах үүднээс "Бүс нутаг болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ" бүрдүүлэх, хөгжлийн төлөө хамтран ажиллах нь манай гадаад бодлогын тэргүүлэх зорилтын нэг хэвээр байгаа бөгөөд нээлттэй байх нь энэ зорилгод хүрэх гол нөхцөл мөн.

2. Хүний аюулгүй байдлыг хангахуй

Хүний аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн төвтэй хөгжлийг дэмжих нь эдүгээ манай Засгийн газрын гол зорилт болж байна. Энэ тухай миний бие НҮБ-ын өнгөрсөн чуулганд үг хэлэхдээ зориуд тэмдэглэн ярьсан. Монголчууд бидний эрхэмлэдэг зүйл бол монгол хүн, түүний амьдрах баталгаатай орчинг бүрдүүлэх, ардчилсан ёс, хүний эрхийг хүндэтгэх явдал юм. Энэ бол Монголын ард түмний нэгэнт хийсэн эрэлт буцалтгүй сонголт. Үүнийг Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын, Гадаад Бодлогын үзэл баримтлалд ч заасан билээ. Бид НҮБХХ-ийн суурин

төлөөлөгчийн газартай хамтран "Хүний аюулгүй байдал – Сайн засаглал" гэсэн хөтөлбөр боловсруулж мөрдөх, түүнийг шинэ засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд бодлогын гол чиглэл болгохоо мэдэгдсэн. Монгол Улсын Засгийн газар хүний аюулгүй байдлыг НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннаны хэлсэнчлэн "айх аюул, дутагдах гачигдахаас ангид байх явдал" /freedom from fear, freedom from want/ хэмээн тодорхойлохын сацуу хүнийг гачигдах дутагдахаас ангид байх эрхээр хангаж, элбэг хангалуун, сайн сайхан амьдрах орчныг бүрдүүлэх нь Монгол Улсын хувьд хүний аюулгүй байдлын үндсэн зорилт байх болно

хэмээн үзэж байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн бүс хамгаалал, хувь хүний идэвх санаачилга гол үүрэгтэй байх бөгөөд байгууллага, хувь хүний идэвх санаачилга гол үүрэгтэй байх бөгөөд төрөөс тэдэнд гадаад харилцааны шугамаар дэмжлэг туслалцаа үзүүлэх юм. Ийнхүү хүний аюулгүй байдлыг хангах, иргэний нийгэм, сайн засаглалыг хөгжүүлэх, ардчилсан нийгэмд хүний өв нийгэм, нэр төртэй хөгжиж, хуулийг дээдлэх ёсыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах явдал гадаад бодлогын чухал зорилт болсон.

Монгол Улс хүний аюулгүй байдлын салбарт бусад улс, ялангуяа Хүний аюулгүй байдлын сүлжээний гишүүн орнуудтай хоёр талт ба олон талт хамтын ажиллагааг өрнүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай байна.

3. Тогтвортой хөгжлийн таатай орчинг бүрдүүлэхуй

Хүний аюулгүй байдлаас үүдэн тогтвортой хөгжлийн тухай асуудал урган гардаг. Хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд засгийн газар болон бизнес эрхлэгчид түншлэн ажиллахын ач холбогдлыг ухамсарлан, засгийн газрын зүгээс тэдэнд өргөн хүрээтэй, бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх нь чухал юм.

Экспортын хэмжээ, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь улс орны хөгжлийг хурдасгах, ажлын байрыг нэмэгдүүлэх чухал арга зам болно. Нээлттэй, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн тогтолцоог төлөвшүүлэх, шударга өрсөлдөөний орчинг бүрдүүлэх зорилтыг тавих зарчмыг баримталж, засгийн газраас гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогоороо бизнес эрхлэгчдэд илүү таатай нөхцөл бүрдүүлэх, экспортын шинэ зах зээлд нэвтрэх, нэгэнт гарсан зах зээлд байр сууриа бэхжүүлэхэд нь дэм үзүүлэхийг чухалчилж байна. Манай томоохон объектуудыг

435

хувьчлах үйл явц эхлэх гэж байгаатай холбогдуулан зарлаагч тендэрт гаднын түншүүдийг оролцуулахад чиглэсэн үйл ажиллагаа гадаад харилцааны салбарт ажиллагсдын үйл ажиллагаа чиглэж учиртай.

Хандивлагчидтай ажиллах асуудал энд чухал байр эзлэж өстөй. Монголд туслах хандивлагчдын хөдөлгөөн Монгол орны хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болсныг бид хэнээр ч хэлүүлэлтгүй сайн мэдэж байгаа. Үүнд өнөөгийн өөрчлөгдөн байгаа нөхцөл байдалд хандивлагчидтай ажиллах арга барилгаа байнга шинэчлэн төгөлдөржүүлэхгүй бол болохгүй боллоо. Хандивлагчдын хөдөлгөөнийг яаж илүү үр ашигтай, үр өгөөжтэй ашиглах вэ гэдгийг бид их нят бодох ёстой. Нэг үгээр хэлбэл хандивлагчидтай ажиллах хэлбэрээ бид зөв сонгон олох цаг боллоо.

4. Хүний нөөцийг хөгжүүлэхүй

XXI зуун бол мэдээллийн технологийн эрин үе гэдэгт нийцүүлэн мэдлэг оюунд тулгуурлах хөгжлийн стратеги нь хамгийн ирээдүйтэй арга байх болно. Шинэ зуунд дэлхийн улс орнуудын хөгжлийн хурдац тэдний газар зүйн байршил, байгалийн нөөц баялгаас голчлон шалтгаалах бус, харин хүн амын нь мэдлэг боловсрол, түүнийгээ хэрхэн зөв оновчтой ашиглахаас ихээхэн хамаарна. Тиймээс энэ зууныг оюуны зуун ч гэх нь бий.

Мэдээллийн технологи газар зүйн хувьд түгжигдмэл байршилтай Монгол оронд гадаад ертөнцтэй худалдаа, соёл, хүмүүнлэгийн солилцоог өргөжүүлж, хүн амынхаа оюуны чадамжид тулгуурлан хурдацтай хөгжих шинэ боломжийг нээж байна. Иймд хүн амын мэдлэг, боловсролын нягтралыг сайжруулж, хүний нөөцийн хөгжлийг онцгой ач холбогдолтойд үзэх нь Монгол орны хөгжлийн нэгэн чухал суурь хөрс болох нь тодорхой бөгөөд үүнд манай гадаад бодлого зарчмын чухал үүрэг гүйцэтгэх ёстой.

Ийнхүү глобалчлалын үйл явцад үр ашигтай, идэвхтэй оролцож тулгарах сорилтуудыг бусад улс оронтой хамтран ажиллах замаар шийдэн, ардчилсан ёс, хүний эрхийг дээдэлсэн, нээлттэй, чөлөөт эдийн засгийг эрхэмлэсэн тогтолцоог тууштай хөгжүүлэхэд гаднын хүчин зүйл шийдвэрлэх үүрэгтэй хэвээр байна.

Энд нэг асуудлыг зориуд цохон тэмдэглүүлштэй байна. Өнөөдөр манай иргэд гадаадад олноор амьдрах боллоо. Үүнтэй уялдаж гадаад дахь манай иргэдийн нийгмийн асуудал, хоёрдмол харьяаллын асуудал, өмч хөрөнгийн асуудал зэрэг урьд өмнө тохиолдож байгаагүй цоо шинэ олон асуудал гарч эхэллээ. Үүний сацуу манай иргэд очсон улс орондоо гэмт хэрэг, хулгай дээрэм хийх зэрэгээр тухайн улсын хууль дүрмийг ноцтой зөрчих явдал гарсаар байна. Нөгөөтэйгүүр, өрнө дорнын өндөр хөгжилтэй орнуудад манай иргэд зорчих нь хязгаарлагдмал шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, гадаад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хувьд илүү ашигтай эрх зүйн шинэ гарц, шийдвэр эрж хайх нь бидний ойрын жилүүдэд амжилт хийх томоохон ажил байх бөгөөд үүнтэй холбогдуулан барьцтай бодлого боловсруулах шаардлага аяндаа урган гарч байна гэж үзнэ.

5. Олон нийттэй ажиллахуй

Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд гадаад дахь Монголын тухай төсөөлөл ихээхэн өөрчлөгдсөн. Монголчууд төр засгийнхаа гадаад бодлого, дипломат үйл ажиллагааг сайтар ойлгон мэдэж, санал бодлоо илэрхийлдэг, нөгөө талаас гадаад ертөнц Монгол улсыг зөв таньж мэдэн харилцаж байх асуудал Засгийн газрын гадаад үйл ажиллагааны анхаарлын төвд байх учиртай.

Гадаад улс орнуудад Монгол Улсыг таниулах ажилд хилийн чанад дахь монгол гаралтай хүмүүс, боловсрол, соёл, урлаг, мэдээллийн олон улсын байгууллага, сангуудтай тодорхой ажиллах шаардлага буйг дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

Гадаад болон дотоод сурталчилгааг тодорхой бодлоготой, цэгцтэй болгох тухай энд ярьж байна. Дотоод сурталчилгаа гэдэгт төр, засгийн гадаадад чиглэсэн үйл ажиллагааг өөрийн улсын олон нийтэд зөв, шуурхай, цэгцтэй таниулахтай холбогдож буй гэдгийг та бүхэн ойлгож байгаа биз ээ. Энэ ажлыг чухал ач холбогдолтойд үзэж, тодорхой хандах цаг болсон.

Монгол Улс, гадаад орнуудын харилцан ойлголцлыг өргөжүүлэх, Монгол Улсын үндэсний эрх ашгийг бэхжүүлэх зорилгоор гадаадын байгууллагууд, олон нийтийг ойлгож мэдэх, тэдэнд мэдээлэл хүргэх, нөлөөлөх зэрэгт сурталчилгаа, мэдээллийн ажил чиглэх ёстой.

Монгол Улсын гадаад бодлогын үндсэн зорилтын хэрэгжилт нь зөвхөн засгийн газрын хамтын ажиллагаанаас бус иргэд, төрийн бус байгууллагууд бизнесүүдийн хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаанаас үлэмжхэн шалтгаална. Манай төрийн гадаад бодлогын нэг чухал зорилт бол энэ холбоо, хамтын ажиллагааг тогтоож, хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл, манай гадаад бодлого олон тулгууртай байгаад, зогсохгүй дотооддоо ч бат түшигтэй байх учиртай. Иймд олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд иргэд, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хөгүүлэн дэмжихэд онцгой анхаарах ёстой байна.

6. Шинэ зуун, шинэчлэгдсэн үзэл баримтлал

Эдүгээ Монгол Улс гадаад харилцаандаа 1994 онд батлагдсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Гадаад бодлогын үзэл баримтлал"-ыг урт хугацааны тогтвортой бодлого, чиглэл болгон баримталж ирлээ.

Гадаад бодлогын үзэл баримтлалд тунхагласан, Монгол Улсын хөгжлийн тодорхой шатанд тавигдаж ирсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн олон тулгуурт гадаад бодлого өнөрсөн жилүүдэд үр дүнгээ өгсөн бөгөөд цагийн шалгуурыг амжилттай даван тууллаа гэж үзэх бүрэн үндэстэй. Эл үзэл баримтлал нь шилжилтийн үеийн Монгол Улсын гадаад бодлогын стратегийн зорилтыг тодорхойлсныхоо хувьд ч, улс төрийн хүчнүүдийн зөвшилцлийн үндсэн дээр батлагдаж чадсаны хувьд ч зарчмын ач холбогдолтой, шинэ зүйл байсан. Түүний үндсэн заалт болох олон тулгууртай байх, нээлттэй байх, хөрш хоёр оронтой тэнцвэртэй харилцах зэрэг зарчмын заалт одоо ч үйлчилж байгаа цаашид ч хэвээр байх болно.

Нөгөөтэйгүүр, цаг хугацаа улиран өнгөрөх тутам Монгол Улсыг гадаад бодлого, гадаад харилцааны өмнө шинэ шинэ, төсөөлөхөд амаргүй асуудлууд гарч ирж байгааг ч мөн үгүйсгэх аргагүй.

Үзэл баримтлалд "Монгол Улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахинд болон бүс нутгийн улс төрийн байдалтай нягт уялдуулан тэргүүлэх чиглэл, зорилтыг нь тогтоохдоо уян хатан хандаж байна" гэж заасаа байгаа. Үзэл баримтлалыг баталснаас хойш даруй 7 жил өнгөрсө-

Бөгөөд энэ хугацаанд Монгол Улсын дотоодод төдийгүй олон улсын харилцаанд ч томоохон шинэчлэл өөрчлөлт гарлаа. Эдгээр өөрчлөлт өдгөө Монгол Улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагааны агуулгыг тодорхойлж байна.

Үүнээс үүдэн Гадаад бодлогын үзэл баримтлалыг уян хатан байх гэдэг утгаар нь шинэчилж баяжуулах шаардлага аяндаа гарч байна гэж бодож байна. Энэ ажилд манай эрдэмтэд мэргэд, дипломатууд, ахмадууд өөр өөрсдийн мэдлэг чадвар, туршлага, буюн ухаанаа зориулна гэдэгт эргэлзэхгүй байгаагаа эцэст нь илэрхийлбэ.